

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар А-254

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, мэдээлэл цуглуулах, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газар /Я.Эрдэнэсайхан/-т үүрэг болгосугай.
3. Тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Хуулийн хэлтэс /Э.Цолмонжаргал/-т даалгасугай.

САЙД З.МЭНДСАЙХАН